

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Санхүү хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/04-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Ахлах аудитор: С.Баасансүрэн Утас: 7036-2442 Цахим хаяг: <a href="mailto:Baasansurens@audit.gov.mn">Baasansurens@audit.gov.mn</a>
---	---

Энэхүү тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

1. Аудитын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-10
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	11-14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12-13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13-14
4. Аудитын тайлан	15-20
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15-16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16-17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	17-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

### **Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮ ХЯНАЛТ,  
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
О.БАЗАРРАГЧАА ТАНАА

2023.02.25 № СА-2023/04-НА-СТА-ТҮС  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Санхүү хяналт, аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Санхүү хяналт, аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн тэтгэмж, унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож олгосон, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан, анхан шатны бүрдэлгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан, төсөвт тусгагдаагүй орон тоог хавсран гүйцэтгүүлсэн зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.3, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.1, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Сэлэнгэ аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 93.0 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 7.0 хувиар хэмнэсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Сэлэнгэ аймгийн Санхүү хяналт, аудитын албаны 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 58.3 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал эзэлж байгаа бөгөөд хангамж, бараа материалын зардалд 17,737.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 9,686.2 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 9,328.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд 895.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 630.0 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардалд 39,191.7 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд танилцуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,752,474.21</b>	<b>1,676,597.37</b>
33	<b>АВЛАГА</b>	<b>124,474.21</b>	<b>45,597.37</b>
33500	<b>Бусад авлага</b>	<b>124,474.21</b>	<b>45,597.37</b>
33510	Байгууллагаас авах авлага	124,474.21	45,597.37
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>2,628,000.00</b>	<b>1,631,000.00</b>
35400	<b>Хангамжийн материал</b>	<b>2,628,000.00</b>	<b>1,631,000.00</b>
35420	Аж ахуйн материал	863,000.00	1,586,000.00
35470	Бусад хангамжийн материал	1,765,000.00	45,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,814,828.88</b>	<b>15,748,518.46</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>13,814,828.88</b>	<b>15,748,518.46</b>
39200	<b>Биет хөрөнгө</b>	<b>13,470,162.26</b>	<b>15,579,851.88</b>
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	16,158,000.00	20,077,900.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,505,944.56	-11,229,274.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,775,600.00	10,775,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,957,493.18	-4,044,373.20
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>344,666.62</b>	<b>168,666.58</b>
39301	Программ хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-535,333.38	-711,333.42
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>16,567,303.09</b>	<b>17,425,115.83</b>
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>16,567,303.09</b>	<b>17,425,115.83</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>16,567,303.09</b>	<b>17,425,115.83</b>
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>16,567,303.09</b>	<b>17,425,115.83</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	16,159,208.18	16,567,303.09
51220	Тайлант үеийн үр дүн	408,094.91	857,812.74
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>16,567,303.09</b>	<b>17,425,115.83</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>132,172,800.00</b>	<b>186,897,900.61</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>132,172,800.00</b>	<b>186,897,900.61</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>132,172,800.00</b>	<b>186,897,900.61</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,172,800.00	186,897,900.61
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>131,764,705.09</b>	<b>186,040,087.87</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>131,764,705.09</b>	<b>186,040,087.87</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>130,764,705.09</b>	<b>146,398,387.87</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>88,557,781.48</b>	<b>96,891,323.16</b>
210101	Үндсэн цалин	67,713,620.89	69,970,093.18
210102	Нэмэгдэл	16,716,160.59	17,814,329.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,128,000.00	5,469,604.79
210104	Урамшуулал	0	3,637,295.62
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>12,010,244.31</b>	<b>12,166,854.29</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,458,100.32	9,006,692.53
210202	Тэтгэмжийн даатгал	1,047,115.27	807,621.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	668,007.60	650,020.33
210204	Ажилгүйдлийн даатгал	166,997.30	162,505.14
210205	Эрүүл мэндийн даатгал	1,670,023.82	1,540,015.04
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>12,730,000.00</b>	<b>18,734,700.00</b>
210401	Бичиг хэрэг	3,176,000.00	4,497,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	5,871,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,800,000.00	2,129,900.00
210404	Ном, хэвлэл	24,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,230,000.00	3,822,600.00
210408	Бараа материал акталсны зардал	0	2,413,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,500,000.00</b>	<b>5,766,300.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	539,400.00
210604	Урсгал засвар	0	5,226,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,988,300.00</b>	<b>9,328,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,988,300.00	9,328,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>750,000.00</b>	<b>895,000.00</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	750,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	895,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,228,379.30</b>	<b>2,616,210.42</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	630,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,628,379.30	1,986,210.42
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,000,000.00</b>	<b>39,641,700.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000,000.00</b>	<b>39,641,700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	39,191,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	450,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>408,094.91</b>	<b>857,812.74</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>408,094.91</b>	<b>857,812.74</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>132,172,800.00</b>	<b>186,897,900.61</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>132,172,800.00</b>	<b>186,897,900.61</b>
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>132,172,800.00</b>	<b>186,897,900.61</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	132,172,800.00	186,897,900.61
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>129,922,800.00</b>	<b>182,978,000.61</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>129,922,800.00</b>	<b>182,978,000.61</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>128,922,800.00</b>	<b>143,336,300.61</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>89,698,800.00</b>	<b>96,891,323.16</b>
210101	Үндсэн цалин	62,972,300.00	69,970,093.18
210102	Нэмэгдэл	22,404,500.00	17,814,329.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,322,000.00	5,469,604.79
210104	Урамшуулал	0	3,637,295.62
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>11,735,700.00</b>	<b>12,087,977.45</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,117,400.00	8,877,314.15
210202	Тэтгэмжийн даатгал	906,500.00	773,087.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	722,500.00	650,020.33
210204	Ажилгүйдлийн даатгал	181,700.00	162,505.14
210205	Эрүүл мэндийн даатгал	1,807,600.00	1,625,050.83
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,450,000.00</b>	<b>17,737,700.00</b>
210401	Бичиг хэрэг	3,176,000.00	4,497,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,500,000.00	5,871,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,800,000.00	2,129,900.00
210404	Ном, хэвлэл	24,000.00	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,950,000.00	5,239,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,700,000.00</b>	<b>5,766,300.00</b>
210602	Тавилга	800,000.00	0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,500,000.00	539,400.00
210604	Урсгал засвар	2,400,000.00	5,226,900.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,988,300.00</b>	<b>9,328,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,988,300.00	9,328,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>750,000.00</b>	<b>895,000.00</b>
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	750,000.00	895,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>600,000.00</b>	<b>630,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	600,000.00	630,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,000,000.00</b>	<b>39,641,700.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,000,000.00</b>	<b>39,641,700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0	39,191,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	450,000.00
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>2,250,000.00</b>	<b>3,919,900.00</b>

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,250,000.00	3,919,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,250,000.00	3,919,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,250,000.00	3,919,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,250,000.00	3,919,900.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,250,000.00	-3,919,900.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	16,159,208.18	16,159,208.18
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	16,159,208.18	16,159,208.18
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	408,094.91	408,094.91
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	16,567,303.09	16,567,303.09
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	16,567,303.09	16,567,303.09
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	16,567,303.09	16,567,303.09
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	857,812.74	857,812.74
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	17,425,115.83	17,425,115.83

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>200,999,700.00</b>	<b>186,897,900.61</b>	<b>14,101,799.39</b>	<b>93.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>200,999,700.00</b>	<b>186,897,900.61</b>	<b>14,101,799.39</b>	<b>93.0</b>
210	Бараа, үйлчилгээний зардал	160,568,000.00	147,256,200.61	13,311,799.39	91.7
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>104,767,000.00</b>	<b>96,891,323.16</b>	<b>7,875,676.84</b>	<b>92.5</b>
210101	Үндсэн цалин	71,727,700.00	69,970,093.18	1,757,606.82	97.5
210102	Нэмэгдэл	22,046,100.00	17,814,329.57	4,231,770.43	80.8
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	6,720,000.00	5,469,604.79	1,250,395.21	81.4
210104	Урамшуулал	4,273,200.00	3,637,295.62	635,904.38	85.1
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,095,900.00</b>	<b>12,087,977.45</b>	<b>1,007,922.55</b>	<b>92.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	8,906,000.00	8,877,314.15	28,685.85	99.7
210202	Тэтгэмжийн даатгал	1,047,200.00	773,087.00	274,113.00	73.8
210203	ҮОМШӨ ний даатгал	838,000.00	650,020.33	187,979.67	77.6
210204	Ажилгүйдлийн даатгал	209,200.00	162,505.14	46,694.86	77.7
210205	Эрүүл мэндийн даатгал	2,095,500.00	1,625,050.83	470,449.17	77.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,595,800.00</b>	<b>17,737,700.00</b>	<b>858,100.00</b>	<b>95.4</b>
210401	Бичиг хэрэг	4,497,000.00	4,497,000.00	-	100.0
210402	Тээвэр (шатахуун)	5,871,800.00	5,871,800.00	-	100.0
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,988,000.00	2,129,900.00	858,100.00	71.3
<b>210406</b>	<b>Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс</b>	<b>5,239,000.00</b>	<b>5,239,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
2106	Эд хогшил худалдан авах	12,696,100.00	9,686,200.00	3,009,900.00	76.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,750,000.00	3,919,900.00	2,830,100.00	58.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	719,200.00	539,400.00	179,800.00	75.0
210604	Урсгал засвар	5,226,900.00	5,226,900.00	-	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>9,328,000.00</b>	<b>9,328,000.00</b>	<b>-</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	9,328,000.00	9,328,000.00	-	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>1,365,200.00</b>	<b>895,000.00</b>	<b>470,200.00</b>	<b>65.6</b>
210806	Мэдээллийн технологийн зардал	1,365,200.00	895,000.00	470,200.00	65.6
<b>2201</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>720,000.00</b>	<b>630,000.00</b>	<b>90,000.00</b>	<b>87.5</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	630,000.00	90,000.00	87.5
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>40,431,700.00</b>	<b>39,641,700.00</b>	<b>790,000.00</b>	<b>98.0</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>40,431,700.00</b>	<b>39,641,700.00</b>	<b>790,000.00</b>	<b>98.0</b>
213206	Ээлжийн амралтаар орон нутаг явах унааны зардал	240,000.00	-	240,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	39,191,700.00	39,191,700.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,000,000.00	450,000.00	550,000.00	45.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>186,897,900.61</b>	<b>186,897,900.61</b>	<b>-</b>	<b>100.0</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>186,897,900.61</b>	<b>186,897,900.61</b>	<b>-</b>	<b>100.0</b>

132001	Орон нутгийн төсвөөс	186,897,900.61	186,897,900.61	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	7.00	7.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	5.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1.00	1.00	-	100.0

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Санхүү хяналт, аудитын алба /цаашид Санхүү хяналт, аудитын алба гэх/ нь “ Аймгийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлэх замаар төсвийн хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах, хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн хараат бус бодит дүгнэлт гарган аймгийн удирдлагын засаглалын эрсдэлийг бууруулах, төсөв санхүүгийн сахилга батыг сахиулах, төсвийн хөрөнгийн зохистой бүрдүүлэлт, зарцуулалт, үр ашигтай байдлыг бий болгох” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны А/75 дугаар захирамжаар баталсан “Санхүү хяналт, аудитын албаны дүрэм”-ийн 5.1-д тус албаны үйл ажиллагааны чиглэл, хийх аудитыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж дүрэм, журам, стандарт, гэрээг мөрдөж байгаа байдалд хяналт шалгалт, аудит хийх,
- Төсвийн хөрөнгийн зүй зохистой, үр ашигтай зарцуулалтад аудит хийх,
- Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалтад аудит хийх,
- Төрийн сангийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, аудит хийх,
- Нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв, найдвартай байдалд аудит хийх,
- Санхүүгийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдалд хяналт шалгалт, аудит хийх,
- Хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүртгэл, ашиглалт, зарцуулалт, өмчлөлийн байдалд аудит хийх,
- Байгууллагын дотоод хяналтын болон засаглал, эрсдэлийн удирдлагын тогтолцооны үр ашигтай байдалд аудит хийх,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэрээр тусгайлсан аудит хийх,
- Холбогдох стандартын хүрээнд тодорхойлсон бусад аудит хийх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,

- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох” тухай 107 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон,
- Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/75 дугаар захирамжаар “Санхүү хяналт, аудитын албаны дүрэм”-ийг шинэчлэн баталсныг дагаж мөрдсөн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Санхүү хяналт, аудитын албаны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн ЗДТГ-ын СХТС-ийн хэлтсээс хяналт тавьж, ажилладаг бөгөөд тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Санхүү хяналт, аудитын алба нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүү хяналт, аудитын алба нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Санхүү хяналт, аудитын албаны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 857.8 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	124.5	45.6	(78.9)
Бараа материал	2,628.0	1,631.0	(997.0)
Үндсэн хөрөнгө	13,814.8	15,748.5	1,933.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>16,567.3</b>	<b>17,425.1</b>	<b>857.8</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	<b>16,567.3</b>	<b>17,425.1</b>	<b>857.8</b>
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>16,567.3</b>	<b>17,425.1</b>	<b>857.8</b>

Авлага дансны үлдэгдэл 78.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд НДШ-ийн авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 1,631.0 мянган төгрөг болж 997.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 21,734.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон албаны даргын 2022 оны А/07 дугаар тушаалаар 1,648.4 мянган төгрөгийн, А/18 дугаар тушаалаар 765.0 мянган төгрөг зэрэг нийт 2,413.4 мянган төгрөгийн бараа материалыг акталж, данс бүртгэлээс хассан, 20,317.7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 31,733.5 мянган төгрөг болж 3,919.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,599.9 мянган төгрөгийн үнэтэй Dell маркийн зөөврийн компьютер 1 ширхэг, тус бүр нь 660.0 мянган төгрөгийн үнэтэй Erpson маркийн өнгөт принтер 2 ширхэг зэрэг нийт 3,919.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 17,425.1 мянган төгрөг болж 857.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Санхүү хяналт, аудитын албаны 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 200,999.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 39,191.7 мянган төгрөгөөр бууруулж /тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 39,191.7 мянган төгрөгөөр бууруулснаас шалтгаалсан байна./ 122,616.3 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 39,191.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 200,999.7 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 186,897.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 186,897.9 мянган төгрөг буюу 93.0 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 7,875.6 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 1,007.9 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 858.1 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 3,009.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 470.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 90.0 мянган төгрөгөөр, ээлжийн амралтаар орон нутаг явах унааны зардлыг 240.0 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 550.0 мянган төгрөгөөр гэх мэт батлагдсан төсвийг нийт **14,101.8** мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	160,568.0	147,256.2	13,311.8	91.7
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	40,431.7	39,641.7	790.0	98.0
	<b>Нийт</b>	<b>200,999.7</b>	<b>186,897.9</b>	<b>14,101.8</b>	<b>93.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус албаны нэмэлт санхүүжилтийн 100130051416 тоот дансанд тайлант онд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Санхүү хяналт, аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл болон төлбөрийн цахим баримттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Баасансүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Санхүү хяналт, аудитын алба нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 131,764.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,317.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын даргын 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 02/857 дугаар албан бичгээр чиглэл өгсөн бөгөөд тус алба нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 7.6 хувь буюу 8,883.6 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 28.7 хувь буюу 858.1 мянган төгрөгөөр,
- Эд хогшил худалдан авах, урсгал засварын зардлыг 23.7 хувь буюу 3,009.9 мянган төгрөгөөр,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлыг 34.4 хувь буюу 470.2 мянган төгрөгөөр,
- Нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлыг 55 хувь буюу 550.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн бөгөөд ээлжийн амралтаар орон нутаг явах унааны зардал гаргалгүй ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих дараах 29 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

- Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны мэдээллийг 9 удаа,
- Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийн мэдээллийг 8 удаа,
- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг 3 удаа,
- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 6 удаа,
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг 3 удаа гэх мэт.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана:”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Бусад хууль, тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал гараагүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 792.7 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулж, 9,735.6 мянган төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлэн 12,126.6 мянган төгрөгийн 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг аудитаар дахин хянахад 40.0 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	792.7	1	792.7	100
Албан шаардлага	1	9,735.6	1	9,735.6	100
Зөвлөмж	3	12,126.6	-	-	
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>22,654.9</b>	<b>2</b>	<b>10,528.3</b>	<b>40.0</b>

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс тайлант онд албаны дарга Б.Дарихжавын илүү ажилласан цагийг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулалгүйгээр 1,206.6 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл олгосон, 1,459.9 мянган төгрөгийн худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй буюу зөрчлүүдийг давтан гаргасан байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой залруулсан алдаа гараагүй болно.

Аудитаар нийт 14,149.1 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,088.6 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10,838.6 мянган төгрөгийн 6 зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 2,221.9 мянган төгрөгийн 2 зөрчилд зөвлөмж өгөв.

### **5.1 Төлбөрийн акт**

1.Тус албаны дарга Б.Дарихжавт өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламжид 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний буюу 39,191.7 мянган төгрөгийг олгосон атал нэг сарын үндсэн цалин 1,088.6 мянган төгрөг /“Б.Дарихжавт нэг сарын цалин олгох тухай” 2022.10.06-ны өдрийн А/11 дүгээр тушаалд хөрөнгө мөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан бус буюу тус албаны улсын байцаагч, дотоод аудитор А.Энх-Амгалан гарын үсэг зурж баталгаажуулсан./ -ийг давхардуулан олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Төрийн албаны тухай хуулиас бусад хуульд албан хаагчид тэтгэвэрт гарахад нь нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгохоор заасан бол албан хаагч тэдгээрээс аль илүүг сонгох эрхтэй бөгөөд давхардуулан олгохгүй.”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.2 дахь “... Төрийн албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн дээд хэмжээ нь тухайн албан хаагчийн 36 сарын албан тушаалын үндсэн цалингийн дунджаас ихгүй байна.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулж олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### **5.2 Албан шаардлага**

1. Албаны дарга болон албан хаагчдын Улаанбаатар хот, Дархан-Уул аймаг болон сумдад томилолтоор ажилласан хугацаанд 904.0 мянган төгрөгийн унаа, хоолны хөнгөлөлтийг давхардуулан тооцож олгосон байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон унаа, хоолны хөнгөлөлтийг 2023 оны төсөвт нөхөн суутгах албан шаардлага хүргүүлэв.

2.Хяналт шалгалтын мэргэжилтэн, дотоод аудитор Э.Наранбаярын 2, 3, 4 дүгээр улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг тухай бүр үндсэн цалингийн 40 хувиар тооцож олгосон боловч албаны даргын 2022 оны А/16 дугаар тушаалаар “Байгууллагын аварга” гэх үндэслэлээр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний буюу 414.0 мянган төгрөгийн шагнал урамшууллыг шагнал урамшууллын зардлаас бус цалингийн батлагдсан төсвөөс олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэх.

3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс нийт **2,982.5** мянган төгрөгийн дараах зөрчлүүдийг давтан гаргасан байна. Үүнд:

- Албаны дарга Б.Дарихжавын илүү ажилласан цагийг эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулалгүйгээр 1,206.6 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон,
- Тайлант онд цахим баримтаар баталгаажаагүй 1,775.9 мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн,

Эдгээр нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 3.1 дэх “Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу ... нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж, баталгаажуулсны үндсэн дээр ...”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

4. Байгууллагын бүтэц, орон тоонд батлагдаагүй хөдөлмөр аюулгүй байдал, техник хэрэгсэл цахим сүлжээ, хяналт шинжилгээ үнэлгээ хийх, хяналт шалгалтын бүртгэл хөтлөлтийн ажлыг 4 албан хаагчаар хавсруулан гүйцэтгүүлсэн гэх үндэслэлээр нийт 3,602.1 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:” 16.5.3 дахь “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан орон тооны хязгаарт багтаан орон тоо, цалин хөлсийг тогтоож байх албан шаардлага хүргүүлэв.

5. Жолоочийн тооцооны хуудас зэрэг анхан шатны баримтыг огт бүрдүүлэлгүйгээр тайлант оны 7-12 дугаар саруудад 2,936.0 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан бөгөөд 1-6 дугаар сарын шатахууны зарлагын баримтыг үйлдсэн, хүлээн авсан, хянасан болон зөвшөөрсөн ажилтны гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулаагүй, шаардах хуудас бичигдээгүй зэрэг анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны

баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Санхүүгийн тайлан, тодруулгатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх “Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа гаргах үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна.” 8.1.5 дахь “санхүүгийн тайлангийн тодруулга.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хуульд заасны дагуу тайлант оны санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, онцлог байдлыг илтгэсэн тайлбар, тодруулгуудыг иж бүрэн хийж байх.

#### **2. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Тайлант онд бичгийн цаас, цай, кофе, маск, гар ариутгагч зэрэг нийт 2,221.9 мянган төгрөг / Арвижих цахиур ХХК-иас 1,669.8 мянган төгрөгийн, Оюунумун гэгээ ХХК-иас 552.1 мянган төгрөгийн/ -ийн худалдан авалтын цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “... Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. ...” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авалтыг бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ нэг бүрийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тэтгэмж давхардуулан олгосон	1	1,088.6	1	1,088.6								
Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1	414.0			1	414.0						
Унаа, хоолны хөнгөлөлт давхардуулан тооцож олгосон.	1	904.0			1	904.0						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргасан.	2	2,982.5			2	2,982.5						
Байгууллагын бүтэц, орон тоонд батлагдаагүй ажлыг хавсруулан гүйцэтгүүлсэн гэх үндэслэлээр нэмэгдэл цалин олгосон.	1	3,602.1			1	3,602.1						
Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан.	1	2,936.0			1	2,936.0						
Санхүүгийн тайлангийн тайлбар, тодруулгыг иж бүрэн хийгээгүй.	1	-					1	-				
Цахим төлбөрийн баримтыг нэр төрөл, тоо хэмжээ тус бүрээр бус бөөн дүнгээр баталгаажуулсан.	1	2,221.9					1	2,221.9				
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>14,149.1</b>	<b>1</b>	<b>1,088.6</b>	<b>6</b>	<b>10,838.6</b>	<b>2</b>	<b>2,221.9</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс		Зөвлөмж	
					Албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс зөрчлийг давтан гаргаж мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	29	-			29			
<b>Нийт</b>	<b>29</b>				<b>29</b>			